

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Эрдэнээ	Дугаар	L302
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Чандмань-өндөр сум
Төрсөн газар	Чандмань -Өндөр сум	Төрсөн он	1936
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Аригийн доод хүрээ	Сүм хийдийн дугаар	ХӨЧӨ 047
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 12	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат



Хөвсгөл аймгийн Чандмань-өндөр сумын Аригийн доод хүрээ

Мөнхбат: Тэгэхээр та одоо бас тус сумын шашин түүхтэй холбоотой зарим одоо мэдээ материалуудыг цуглаж, ямар нэгэн хэмжээгээр түүхийн талын ном бичгээр ингээд тодорхой хэмжээгээр материал цуглуулсан гэж сонссон. Ингэхээр танаас дараах асуултыг асууя.Тэгэхээр Засагт хан аймгийн Далай гүний хошууны шашин номын томоохон төв байсан энэ Аригийн доод хүрээний үүсэл хөгжил, шашны мандан бадралынхаа үед энэ хүрээ одоо хичнээн ламтай байсан, ямар ямар сүм дацантай байсан, жасын хэмжээ одоо хэр хэмжээний жастай байсан энэ талаар та мэдээлэл өгнө үү?

Эрдэнээ: Чандмань-Өндөр сумд Аригийн доод хүрээ, Хөхөөгийн хүрээ, Рашааны дуган гэсэн шашны олон мөргөлийн газруудын түүриуд байгаа.Энд бол ард түмэн цуглан, нутаг усныхаа хэмжээгээр шашныгаа хүндэтгэн уламжлал ёсоороо тахиж, хурлаа хийж байсан уламжлалтай.Үүнээс хамгийн том нь 1744 онд үүссэн Аригийн

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. 1

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

доод хүрээ буюу Дашгэмпэнлин хийд юм аа.Энэ хүрээ нь арван зургаан дугантай, гучин хоёр жас, аа Гомбо сахиустай, дөрвөн зуун лам, нэг түм мал бүхий жас сангийн мал сүрэгтэй ингэж: ажиллаж байсан байна аа.Эндхийн хүрээний лам нар чиглэл чиглэлдээ нутгийн ард түмний ирээдүйн, цаашдын амьдралыг залгамжлах хүссэн бүян сахиусыг нь залгах хүндэтгэж ёсолж байсан ийм учиртай.Одоо ч гэсэн энэ нутгийн ард түмэн энэ уламжлалаа сэргээн энэ орон нутагтаа шашны төв байгуулахаар ажиллаж байгаа.Энд ялангуяа энэ нутгийн өндөр настан Цэрмаа гэж эмгэн энийг байгуулахад өөрийн итгэл, сэтгэлээрээ хөөцөлдөж мөн одоо хүрээний дуган байгуулаад ажиллаж байгаа.Энд гагцхүү сүүлийн залуу лам нар жаахан дутагдалтай, ном заалгуулах сурах нөгөө лам нарын тоог олшруулах талаар нэлээн их анхаарч байгаа. Нутгийн ард түмэн ч ийм хүсэлтийг их тавьж байгаа.Цаашдаа манай энэ сумын ард түмэнд өөрсдийнхөө бүян заяа, ирээдүйнхээ бодол хүсэлт, бодлогоо уламжилж байх энэ сайхан шашны хүрээ хийдтэй болгож өгөх нь зүйтэй байх гэдгийг уламжлан хүсч байна.

Мөнхбат: За тэгэхээр танаас бас нэг асуулт асууна аа.Тэгэхээр бас энэ асуулт асуухын өмнө тэмдэглэл хийхэд энэ Аригийн доод хүрээ байгаа газар буюу ерөөсөө энэ Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын газар нутгийг дамжин өнгөрдөг Аригийн гол бол монголын нууц товчоонд одоо эдүгээгийнхээ энэ нэрээр гардаг ийм одоо Монголын түүхэнд холбогдох эртний домогт үс мөрөн.Тэгэхээр энэ голын тухай одоо домог яриаг үндлэслэн Чандмань-Өндөр сумынхан, түүний засаг даргын тамгын газар сүүлийн жилүүдэд нэлээн түүх уламжлалаа сэргээсэн сонирхолтой ажлуудыг сум орон нутаг болон улсын хэмжээнд хийсэн.Тэрний хамгийн сүүлийн жишээ нь өнгөрсөн 2006 онд Их монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн үеэр одоо Алунгоо ээжийн сургаалийн баяр хэмээх энэ одоо томоохон ажлыг хийж хүүхэд залуучуудад эх орон ард түмнийхээ ёс заншлаас сурах ийм томоохон дорвитой ажлуудыг хийснийг бид бүхэн мэдэж байна аа.Тэгэхээр энэ Аригийн голын сав нутагт байх Аригийн доод хүрээ хэмээх энэ хүрээний түүриас зүүн хойшоо одоо эртний тахилгат овоо, Лусын овоо гэж байдаг. Тэгэхээр энэ Лусын овоо гэдэг энэ овооны түүх уламжлал, тахилгын талаар та одоо бидэнд ахмад үеэсээ өвөг дээдсээсээ ямар зүйлийг мэдэж авч үлдсэн бэ, энэ талаар та бид бүхэнд ярьж өгнө үү?

Эрдэнээ: За би яахав ээ, энэ талаар дуулсан сонссон юмаа ярья.Аригийн гол гэдэг бол Чингисийн үүх домогтой холбоотой.Чингис явж байхдаа, Аригийн гол руу, цэргүүд нь явж байгаад Аригийн гол руу айргаа унагаад асгачихсан учраас Айрагийн гол гэж нэртэй байгаад, сүүлд нь Аригийн гол болсон байгаа юм.Ер нь Чингисийн домог бол энүүгээр эхлэлтэй.Эзэн хаан Чингис баруун зүгийн оронд дайлаар явж байхдаа бол энүүгээр цэрэг буюу баатрууд нь өөрөө энүүгээр дамжиж явж байсан, ийм уламжлалтай. Аригийн голоос уусан морь бол хурдан болдог. Аа Аригийн голоос ууж идэж байгаа эмэгтэй бол үзэсгэлэн төгөлдөр сайхан байдаг аа гэсэн ийм нутгийн нэг ийм домог байдаг юм.За тэр нь ч яахав. Энэ голд байдаг, энэ Аригийн голыг тойроод уул хад, уул нуруудынхаа дээгүүр их олон төрлийн янзын нууруудтай.Энэ тайга дотроо бол их үзэсгэлэнт сайхан, арвин их устай ийм газар байдаг юм. За энэ нутагт төрсөн гэж Чингисийн эмэг эх Алунгоо хатныг, энэ түүхийн нууц **Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн 2 хувийн мэдээллээс бүрдсэн болно.**

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

товчоонд ч байдаг бололтой юм. Судалгаа нь ч гарсан. Ингээд энийг бол манай сумын ард түмэн энэ Энхтүвшин даргын санаачилгаар хөөцөлдөж, Алунгоо хатны хөшөөг бол 2005 онд байгуулсан. Ингээд энийгээ хүндэтгэж Алунгоо ээжийн сургаалиар үр хүүхэд удам судраа дамжуулан сурч хүмүүжиж ажиллах ийм юутай байгаа. Тэгээд энэ Аригийн голын одоо доод хүрээ гэхэд бол Аригийн голын наад хүрээнд Лусын овоо гэж. Одоо Алунгоо хатны баруун хойд талд одоо уулын орой дээр байдаг. За энэ Лусын овооны түүх бол Чингисийн баатрын юунд явж байсан Зэлмэ гэж урианхай гаралтай баатар байгаа. Чингисийн амийг хоёр удаа аварсан, тэр нууц товчоонд байдаг. За энэ Аригийн голын одоо Чандмань-Өндөр сумын Шивэрт баг гэж ярьдаг. Нэгдүгээр багийн ард түмний гарал үүсэл нь бол Хэрлэнгийн хөвөөгөөр Чингисийн албыг хашиж явсан ийм албатууд байж байсан байгаа юм, Зэлмийнхээ баатрын юугаар. Тэгээд сүүлдээ нутагтаа ирж энэ Зэлмэ, энэ Ариг усандаа ирж Шивэрт гэдэг газар нутагласан. Энэ Зэлмийн овоо бол харин юу, Урианхай чинь одоо бол зэлмэд байсан. Зэлмийн овоо гэж нэртэй. Лусын овоо гэдэг нь Хэрлэнгийн хөвөөнөөс ирсэн Ариг Урианхай улсуудын овоо байдаг юм. Одоо ч тахигдаж байгаа. Энэ утгаараа энэ бол Зэлмийнхний овоо гэж нэртэй. Зэлмэ гэдэг бол ерөөсөө л Чингисийн албатуудаас тасарч ирсэн, ураг төрлийн улсууд. Ийм учраас Зэлмэ баатар ч энэ нутгаас гарсан байж болзошгүй хэхээм түүхтэй юм аа. Ийм учраас Чандмань-Өндөр сум бол энэ Аригийн гол дагуудаа үүх түүх, түүхийн дурсгалт юмнууд их бий. Соёмбо толгойгоос өгсөөгөөд. Ийм барагдашгүй арвин баялагтай газар.

Мөнхбат: За танд баярлалаа. Ингээд таны өгсөн энэ үнэтэй мэдээлэл Монголын сүм хийдийн түүхэн товчоо судалгааны багийн ажилд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна аа. За тэгээд энд нэг зүйлийг тэмдэглэн хэлэхэд энэ Засагт хан аймгийн Далай гүний хошууны нутаг буюу одоогийн Чандмань-Өндөр сумын нутаг хилийн цэс дотор байрладаг шарын шашны сүм хийдийн томоохон төв болсон Аригийн доод хүрээний тухайн үеийн буюу 19-р зууны сүүлч 20-р зууны эхэн үеийн одоо хүрээ дацангийн зохион байгуулалт за дуганууд за мөн одоо жасуудын байрлал суваргануудын байрлалыг өвөг дээдсээсээ авч үлдсэн аман зургийн байдлаар гаргаж ингэж бүрдүүлсэн тухайн үеийн Аригийн доод хүрээний зураг схемийг сумын өндөр настан Цэрмаа гуай хувилж бидэнд өгсөн юм. За энэ зураг 19-р зууны сүүлч үе 20-р зууны эхэн үе буюу одоогоос зуу гаруй жилийн тэртээх Аригийн доод хүрээний байршлын тухай энэ зураг бол монголын буддын шашны сүм хийдийн түүхэн товчоо судалгааны багийн ажилд маш их үнэтэй ийм том мэдээлэл болно гэдэгт итгэж байна аа. Ингээд та бүхэнд дахин баярлалаа.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн 3
хувийн мэдээллээс бүрдсэн болно.